

АШИГЛАСАН ТҮЛШНИЙ БОЛОН ЦАЦРАГ ИДЭВХТ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ НЭГДСЭН КОНВЕНЦТОЙ ХОЛБООТОЙ ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ

Асуулт: Нэгдсэн конвенц гэж юу вэ?

Хариулт: Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай нэгдсэн конвенц (Нэгдсэн конвенц)-ыг 1997 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр ОУАЭА-аас Вена хотод хуралдуулсан дипломат бага хурлаар соёрхон баталсан. Конвенцыг 1997 оны 09 дүгээр сарын 29-нд гарын үсэг зурахаар нээсэн ба 2001 оны 06 дугаар сарын 18-нд хүчин төгөлдөр болсон.

Нэгдсэн конвенц нь ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны талаар олон улсын хэмжээний цорын ганц заавал дагаж мөрдөх хууль эрх зүйн баримт бичиг юм. Энэ нь зөвхөн цөмийн эрчим хүчний томоохон хөтөлбөрүүдтэй улс орнууд төдийгүй анагаах ухаан, аж үйлдвэр, хөдөө аж ахуй болон судалгаа шинжилгээний зэрэг салбарт цацрагийн үүсгүүрийг ашигладаг улсуудад мөн хэрэглэгддэг.

Асуулт: Нэгдсэн конвенцын хамрах хүрээ юу вэ?

Хариулт: Конвенц нь энхийн зориулалтаар ашиглаж буй цөмийн реакторын ашигласан түлшний менежментийн аюулгүй ажиллагаа болон энхийн зориулалттай хэрэглээнээс үүсэх цацраг цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагаанд хамаарна.

Асуулт: Нэгдсэн конвенцын зорилго юу вэ?

Хариулт: Энэхүү конвенцын зорилго нь нэгдэн орсон талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар дэлхий дахинд ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны соёлыг бий болгох, түүнийг дээд зэргээр хангах, бүх үе шатанд ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хүн ам, нийгэм болон хүрээлэн буй орчныг хамгаалах, цацрагийн сөрөг үр дагавар бүхий ослоос урьдчилан сэргийлэх, ослын хор уршгийг арилгахад оршино.

Асуулт: Нэгдсэн конвенцод нэгдэн орсноор Конвенцын Удиртгал хэсгийн (xi) дүгээр зүйлд заасны дагуу манай улс өөрийн улсын экспортолсон ураны хүдрийн баяжмалаас бий болсон цөмийн хаягдлыг эсхүл олон улсын цөмийн хаягдлыг өөрийн улсын газар нутагт булшлах эрх зүйн үндэс бүрдэх үү?

Хариулт: Монгол Улс ураны хүдрийн баяжмал экспортлох үед тухайн баяжмалыг цаашид боловсруулан ашигласан түлшийг Монгол Улсын нутаг дэвсгэрт буцаан нэвтрүүлэх талаарх зохицуулалт энэ конвенцод тусгагдаагүй. Конвенцын Удиртгал хэсгийн (xi)-т дурдагдсан “үүссэн улс” гэдэг нь цөмийн эрчим хүчний станцад хэрэглэхээр хүлээн авсан түлшийг цөмийн реакторын голомтод хуваагдах гинжин урвалаар энерги гарган авч эрчим хүч үйлдвэрлэсний дараа, реакторын голомтоос бүрмөсөн гаргасан ашигласан түлшийг бий болгож буй орныг хэлдэг.

Эсрэгээрээ конвенцод нэгдэн орсноор цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааг хангах манай улсын эрх зүйн орчин сайжирч, үйл ажиллагаагаа олон улсын хэм хэмжээ, шаардлагын дагуу хэрэгжүүлэх нөхцөл бүрдэхээс гадна аливаа гадаад улс орон эсвэл олон улсын цөмийн хаягдлыг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулах, дамжин өнгөрүүлэхийг хориглосон хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Асуулт: Энэ конвенцод нэгдсэнээр Монгол Улсад ямар ашигтай вэ?

Хариулт: Нэгдсэн конвенцод нэгдсэнээр манай улсад дараах боломж бүрдэнэ. Үүнд:

- Хөрш орнуудын хилийн ойр орчим байрлах цөмийн байгууламжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авах замаар өөрийн нутаг дэвсгэр дээр үүсэж болох гаднын нөлөөллийг тооцох, аюулгүй ажиллагааны үнэлгээ хийх, аюулгүй ажиллагааг сайжруулах талаар шаардлага тавих, 3 жил тутам зохион байгуулагдах хуралдаанд оролцож, гишүүн орнуудын тайланг хэлэлцэх, хил дамнасан ослын үед авах арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх боломж үүснэ. Түүнчлэн өөрийн орны хүн ам, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, аюулгүй байдлыг хангах боломж бүрдэх юм.
- Цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааг хангах манай улсын эрх зүйн орчин сайжирч, үйл ажиллагаагаа олон улсын хэм хэмжээ, шаардлагын дагуу хэрэгжүүлэх нөхцөл бүрдэхээс гадна цөмийн хаягдлыг Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулах, дамжин өнгөрүүлэхийг хориглосон хууль эрх зүйн орчин бүрдэнэ.
- Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийг хэрэгжүүлэх олон улсын туршлагыг судална.
- Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн үндэсний зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэн олон нийтэд баталгаа өгөх боломж бүрдэнэ.
- Дэд бүтцээ хөгжүүлэх нөөц бололцоо хязгаарлагдмал байгаа тохиолдолд ОУАЭА зэрэг байгууллагуудаас дэмжлэг авах боломжтой болно.

Асуулт: Нэгдсэн конвенцын онцлог юу вэ?

Хариулт: Нэгдсэн конвенц нь ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын аюулгүй ажиллагааг хангахад чухал хувь нэмэр оруулдаг. Хэлэлцэн тохиролцогч талууд аюулгүй ажиллагааны нарийн арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар үндэсний тайлан боловсруулж бусад бүх Хэлэлцэн тохиролцогч талуудад хүргүүлж дүгнүүлэх, түүнчлэн Хэлэлцэн тохиролцогч талуудын Хянан хэлэлцэх хуралд идэвхтэй оролцох зэргээр тууштай байдлаа илэрхийлдэг.

Конвенцын хэрэгжилтийн хянан хэлэлцэх хурлыг 3 жилд нэг удаа зохион байгуулдаг бөгөөд зөвхөн тус конвенцод нэгдэн орсон улс орнууд оролцох эрхтэй байдаг. Конвенцод нэгдэн орсон улс орнууд конвенцын 20 дугаар зүйлд заасны дагуу хүлээсэн үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх үндэсний тайлангаа боловсруулж, хэлэлцэн тохиролцогч талуудаар хэлэлцүүлэхээр ОУАЭА-т хүргүүлдэг. Конвенцод нэгдсэн улс Хэлэлцэн тохиролцогч талуудын үндэсний тайлантай танилцаж, аливаа сонирхсон улсад санал асуулга тавих эрх, хяналтын тогтолцоо тусгагдсан байдаг.

Өөрөөр хэлбэл энэ нь ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааг гурван жил тутамд нэг удаа хянан хэлэлцэх хурлаар хэлэлцүүлж, өндөр түвшинд хүргэхийг дэмжихэд чиглэсэн “идэвхжүүлэгч” конвенц юм.

Асуулт: Нэгдсэн конвенцоор эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоог хэрхэн хангадаг вэ?

Хариулт: Конвенцын 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу дараах эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоог бий болгоно. Үүнд:

- Цацрагийн аюулгүй ажиллагааг хангахад тавигдах үндэсний шаардлага болон дүрэм, журмыг бий болгох;
- Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх тогтолцоог бүрдүүлэх;
- Ашигласан түлшний, эсхүл цацраг идэвхт хаягдлын менежментийн байгууламжийг тусгай зөвшөөрөлгүйгээр ажиллуулахыг хориглосон тогтолцоог бүрдүүлэх;
- Зохион байгуулалтын хяналтын тавих, зохицуулагч байгууллагын хяналт шалгалт хийх, баримт бичиг хөтлөх болон тайлагнах тогтолцоог бүрдүүлэх;
- Холбогдох дүрэм, журам болон тусгай зөвшөөрөлд заасан нөхцөл шаардлагыг хэрэгжүүлэх;
- Ашигласан түлшний, эсхүл цацраг идэвхт хаягдлын менежментийн шат бүрт оролцох байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхой зааглан тогтоосон байх зэрэг болно.

Иймд энэхүү конвенцод нэгдэн орсноор ашигласан түлш, цацраг идэвхт хаягдлын менежментийн эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоог сайжруулж, тогтвортой хэрэгжүүлэх, аюулгүй ажиллагааг өндөр түвшинд хангах боломж бүрдэх юм.

Асуулт: Конвенцод нэгдэн орсон улс орнууд нэгдсэн тухай төлөвөө цуцлах буюу конвенцоос гарах боломжтой юу?

Хариулт: Боломжтой. Конвенцын 42 дугаар зүйлд заасны дагуу “Хэлэлцэн тохиролцогч аливаа тал Эх хадгалагчид (ОУАЭА-ийн Ерөнхий захирал) бичгээр мэдэгдэх замаар энэхүү конвенцыг цуцалж болно. Ийнхүү цуцлах нь эх хадгалагч мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 1 жилийн дараа, эсхүл мэдэгдэлд заасан түүнээс хойших өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

---xxxXXXxxx---